

БУЛГАН АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Булган сумын Спортын төрөлжсөн сургалттай Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: БУА-2026/129/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2026 он	Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Д.Батцогт Утас: 70342716 Цахим хаяг: @audit.gov.mn Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn “Шинжлэн Магадлахуй ЭЗШ Аудит” ХХК-ийн захирал: С.Оргил Утас: 99197346 Цахим хаяг: info@shinjenmagadlakhui-audit.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.


АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-10
3. Аудитын тайлан.....	11-14
4. Аудитын илрүүлэлт	14
5. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
БСШУЯ	Боловсрол соёл шинжлэх ухааны яам

Хараат бус аудиторын дүгнэлт

 БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР Анхдагчдын өргөн чөлөө 1-120, Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг, 63082, Утас/Факс: 7034-2580 Цахим шуудан: bulgan@audit.gov.mn <u>026.00.24.</u> № <u>034</u> танай _____ ны № _____ т	СПОРТЫН ТӨРӨЛЖСӨН СУРГАЛТТАЙ ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Г.ЭРДЭНЭЧИМЭГ ТАНАА
Өөрчлөлтгүй дүгнэлт	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын Спортын төрөлжсөн сургалттай Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p> <p>Спортын төрөлжсөн сургалттай Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.</p>	
Дүгнэлтийн үндэслэл	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p>	
Асуудлыг онцолсон хэсэг	
<p>Спортын төрөлжсөн сургалттай Ерөнхий боловсролын сургууль нь 2025 онд 57 хүүхэдтэй үйл ажиллагаа явуулж үүнээс 57 хүүхэд үндсэн сургуульд хамрагдаж 100 хувийн гүйцэтгэлээр санхүүжсэн.</p>	
Аудитын гол асуудал	
<p>Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаахаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.</p>	
Бусад асуудлын хэсэг	
<p>Спортын төрөлжсөн сургалттай Ерөнхий боловсролын сургуулийн захирал нь Булган аймгийн боловсролын газрын даргатай 2025 онд байгуулсан</p>	
6326050413	

гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулаагүй ч 5 хөтөлбөр, 20 арга хэмжээний хүрээнд 64.0 хувиар үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТЦОГТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>104,553,321.68</u>	<u>137,524,587.38</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	50,037,646.27	79,434,126.97
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	50,037,646.27	79,434,126.97
3121	Төгрөг	50,037,646.27	79,434,126.97
31211	Төрийн сангийн харилцах	50,037,646.27	79,434,126.97
35	БАРАА МАТЕРИАЛ	54,515,675.41	58,090,460.41
351	Түүхий эд материал	25,007,141.91	25,730,961.91
35110	Тусгай зориулалттай материал	24,956,661.91	25,476,661.91
35130	Эм боох материал	50,480.00	254,300.00
35200	Дуусаагүй үйлдвэрлэл		
35300	Бэлэн бүтээгдэхүүн		
354	Хангамжийн материал	29,508,533.50	32,359,498.50
35410	Бичиг хэргийн материал	2,089,608.00	2,986,108.00
35420	Аж ахуйн материал	17,916,350.00	17,916,350.00
35450	Барилгын засварын материал	852,190.50	852,190.50
35460	Хүнсний материал	8,650,385.00	10,349,850.00
35470	Бусад хангамжийн материал	-	255,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,160,015,476.15</u>	<u>1,061,372,124.98</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,160,015,476.15	1,061,372,124.98
392	Биет хөрөнгө	1,124,249,851.15	1,025,915,874.98
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,031,876,227.86	1,031,876,227.86
39202	Хуримтлагдсан элэгдэл	(158,513,290.08)	(186,476,887.20)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	227,150,703.00	227,150,703.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(58,644,578.04)	(110,677,174.24)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	55,225,632.00	57,105,632.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(11,453,208.33)	(28,159,987.74)
39214	Бусад үндсэн хөрөнгө	61,966,290.73	61,966,290.73
39215	Хуримтлагдсан элэгдэл	(26,413,137.24)	(30,440,074.88)
39217	Ном	3,055,211.25	3,571,145.45
393	Биет бус хөрөнгө	35,765,625.00	35,456,250.00
39301	Програм хангамж	1,350,000.00	1,350,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(984,375.00)	(1,293,750.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	35,400,000.00	35,400,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,264,568,797.83</u>	<u>1,198,896,712.36</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>63,747,750.00</u>	<u>43,708,050.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	63,747,750.00	43,708,050.00
413	Өглөг	63,747,750.00	43,708,050.00
4136	Бусад өглөг	63,747,750.00	43,708,050.00

Булган аймгийн Булган сумын Спортын төрөлжсөн сургалттай Ерөнхий боловсролын сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

41361	Байгууллагад төлөх өглөг	63,747,750.00	43,708,050.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>533,999,148.49</u>	<u>488,366,763.02</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	533,999,148.49	488,366,763.02
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	35,400,000.00	35,400,000.00
51101	Өмч: - төрийн	35,400,000.00	35,400,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	(136,633,329.75)	(182,265,715.22)
51210	Өмнөх үеийн үр дүн	(136,633,329.75)	(136,633,329.75)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(45,632,385.47)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	635,232,478.24	635,232,478.24
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>597,746,898.49</u>	<u>532,074,813.02</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	832,950,500.00	1,048,395,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	832,950,500.00	1,048,395,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	694,747,500.00	877,575,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	694,747,500.00	877,575,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	15,000,000.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,000,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	123,203,000.00	170,820,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	123,203,000.00	170,820,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	894,029,700.20	1,097,618,819.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	894,029,700.20	1,097,618,819.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	883,050,031.49	1,076,241,263.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	565,101,145.06	680,948,075.38
210101	Үндсэн цалин	380,397,242.59	428,903,325.66
210102	Нэмэгдэл	177,168,022.47	226,961,625.17
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	2,275,000.00
210104	Урамшуулал	7,535,880.00	22,808,124.55
210105	Гэрээт ажлын хөлс		
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	71,959,000.00	83,959,548.92
210201	Тэтгэврийн даатгал	48,932,100.00	57,599,320.61
210202	Тэтгэмжийн даатгал	5,756,700.00	6,965,189.13
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,878,400.00	3,337,822.72
210204	Ажилгүйдлийн даатгал	2,878,400.00	3,154,530.36
210205	Эрүүл мэндийн даатгал	11,513,400.00	12,902,686.10

Булган аймгийн Булган сумын Спортын төрөлжсөн сургалттай Ерөнхий боловсролын сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	83,662,681.29	129,442,644.04
210301	Гэрэл, цахилгаан	5,795,441.29	7,009,742.92
210302	Түлш, халаалт	64,225,282.00	108,408,561.12
210303	Цэвэр, бохир ус	13,641,958.00	14,024,340.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,478,140.00	-
210408	Бараа материал акталсны зардал	8,478,140.00	-
2105	Нормативт зардал	36,931,165.00	46,071,930.00
210502	Хоол, хүнс	36,931,165.00	46,071,930.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,996,050.00	20,000,000.00
210604	Урсгал засвар	27,996,050.00	20,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,279,800.00	3,017,411.62
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,279,800.00	3,017,411.62
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	86,642,050.14	112,801,653.75
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,488,110.00	9,919,568.38
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,720,310.00	1,842,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	76,433,630.14	101,039,285.37
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,979,668.71	21,377,555.96
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	10,979,668.71	21,377,555.96
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,979,668.71	21,377,555.96
213404	Хөрөнгийн		
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(61,079,200.20)	(49,223,319.67)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,148,518.38	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,148,518.38	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(1,148,518.38)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(62,227,718.58)	(49,223,319.67)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	834,079,700.00	1,048,395,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,129,200.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	1,129,200.00	-
120009	Бусад орлого	1,129,200.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	832,950,500.00	1,048,395,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	694,747,500.00	877,575,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	694,747,500.00	877,575,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	15,000,000.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,000,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	123,203,000.00	170,820,200.00

Булган аймгийн Булган сумын Спортын төрөлжсөн сургалттай Ерөнхий боловсролын сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	123,203,000.00	170,820,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	<u>828,084,295.06</u>	<u>1,020,538,572.30</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>828,084,295.06</u>	<u>1,020,538,572.30</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>817,104,626.35</u>	<u>999,161,016.34</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	565,101,145.06	682,487,628.38
210101	Үндсэн цалин	380,397,242.59	430,442,878.66
210102	Нэмэгдэл	177,168,022.47	226,961,625.17
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	2,275,000.00
210104	Урамшуулал	7,535,880.00	22,808,124.55
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	71,959,000.00	83,959,548.92
210201	Тэтгэврийн даатгал	48,932,100.00	57,784,279.81
210202	Тэтгэмжийн даатгал	5,756,700.00	6,965,189.13
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,878,400.00	3,337,822.72
210204	Ажилгүйдлийн даатгал	2,878,400.00	2,969,571.16
210205	Эрүүл мэндийн даатгал	11,513,400.00	12,902,686.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	83,662,681.29	129,442,644.04
210301	Гэрэл, цахилгаан	5,795,441.29	7,009,742.92
210302	Түлш, халаалт	64,225,282.00	105,682,101.12
210303	Цэвэр, бохир ус	13,641,958.00	16,750,800.00
2105	Нормативт зардал	40,867,300.00	47,771,395.00
210502	Хоол, хүнс	40,867,300.00	47,771,395.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,560,650.00	20,000,000.00
210604	Урсгал засвар	28,560,650.00	20,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,569,600.00	3,037,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,129,200.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,440,400.00	3,037,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,384,250.00	32,461,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,465,150.00	30,619,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,919,100.00	1,842,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	<u>10,979,668.71</u>	<u>21,377,555.96</u>
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	10,979,668.71	21,377,555.96
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,979,668.71	21,377,555.96
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>5,995,404.94</u>	<u>27,856,927.70</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>49,939,250.00</u>	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>49,939,250.00</u>	-
2200	Дотоод эх үүсвэрээр	49,939,250.00	-
222001	Тоног төхөөрөмж	23,899,250.00	-
223001	Бусад хөрөнгө	26,040,000.00	-

Булган аймгийн Булган сумын Спортын төрөлжсөн сургалттай Ерөнхий боловсролын сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(49,939,250.00)</u>	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(43,943,845.06)	27,856,927.70
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		50,037,646.27
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	50,037,646.27	79,434,126.97

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	702,221,899.34	635,232,478.24	(129,389,741.87)	1,208,064,635.71
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	702,221,899.34	635,232,478.24	(129,389,741.87)	1,208,064,635.71
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(7,243,587.88)	(7,243,587.88)
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	702,221,899.34	635,232,478.24	(136,633,329.75)	1,200,821,047.83
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	702,221,899.34	635,232,478.24	(136,633,329.75)	1,200,821,047.83
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	702,221,899.34	635,232,478.24	(136,633,329.75)	1,200,821,047.83
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(45,632,385.47)	(45,632,385.47)
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	702,221,899.34	635,232,478.24	(182,265,715.22)	1,155,188,662.36

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,112,076,900.00	999,161,016.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,112,076,900.00	999,161,016.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,112,076,900.00	999,161,016.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	761,497,200.00	682,487,628.38
210101	Үндсэн цалин	483,601,900.00	430,442,878.66

Булган аймгийн Булган сумын Спортын төрөлжсөн сургалттай Ерөнхий боловсролын сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

210102	Нэмэгдэл	254,138,400.00	226,961,625.17
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	2,275,000.00
210104	Урамшуулал	23,756,900.00	22,808,124.55
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	95,187,300.00	83,959,548.92
210201	Тэтгэврийн даатгал	64,727,300.00	57,784,279.81
210202	Тэтгэмжийн даатгал	7,615,000.00	6,965,189.13
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,807,500.00	3,337,822.72
210204	Ажилгүйдлийн даатгал	3,807,500.00	2,969,571.16
210205	Эрүүл мэндийн даатгал	15,230,000.00	12,902,686.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	150,820,200.00	129,442,644.04
210301	Гэрэл, цахилгаан	12,000,000.00	7,009,742.92
210302	Түлш, халаалт	125,820,200.00	105,682,101.12
210303	Цэвэр, бохир ус	13,000,000.00	16,750,800.00
2105	Нормативт зардал	49,293,000.00	47,771,395.00
210502	Хоол, хүнс	49,293,000.00	47,771,395.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,000,000.00	20,000,000.00
210604	Урсгал засвар	20,000,000.00	20,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,118,900.00	3,037,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,118,900.00	3,037,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,160,300.00	32,461,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,601,100.00	30,619,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,559,200.00	1,842,700.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,112,076,900.00	1,048,395,500.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	941,256,700.00	877,575,300.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	941,256,700.00	877,575,300.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	170,820,200.00	170,820,200.00
132001	Орон нутгийн төсвөөс	170,820,200.00	170,820,200.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		50,037,646.27
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		79,434,126.97

3. АУДИТЫН ТАЙЛАН

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Булган аймгийн Спортын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллагаас, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Шинжлэн Магадлахуй ЭЗШ аудит ХХК”-ийн аудитын баг С.Дарьсүрэн, Б.Хоролбат нар гүйцэтгэж, гүйцэтгэх захирал С.Оргил анхан шатны чанарын хяналтыг, Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Батцогт нар дараагийн шатны чанарын хяналтыг хэрэгжүүлэн ажилласан.

Булган аймгийн Спортын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2026 оны 02 дүгээр сарын 16-ны өдрийн 08 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны нийт зардалыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны нийт зардлаас 1,097,618.81 мянган төгрөгийн 1.5 хувь 16,464.28 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 11,524.99 мянган төгрөгөөр тогтоосон.

3.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Монгол Улсын Их Хурлаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийг 2022 оны 04 дүгээр сарын 29-нд баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах эрх бүхий байгууллага нь төрийн аудитын байгууллага байна гэж заасан. Үүний дагуу “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэл”-ийг МУЕА-ын 2022 оны 07 дугаар сарын 19-ны өдрийн А/59 дүгээр тушаалаар, “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”-ыг МУЕА-ын 2022 оны 11 дүгээр сарын 25-ны А/89 дүгээр тушаалаар баталж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хянаж ажилласан болно.

Тус байгууллага нь цалин, шимтгэлийн зардал болон бусад зардлуудаас нийт 73,305.79 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгож төрийн сангийн харилцах дансанд үлдээсэн байна. Орон нутгийн санхүүжилтээс 10,602.68 мянган төгрөгийг хэмнэн буцаан төвлөрүүлэн шилжүүлсэн байна.

3.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

3.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Булган аймгийн Спортын сургууль нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 171 мэдээллээс 165 мэдээллийг бүрэн оруулж, мэдээллийг хугацаа хороон мэдээлсэн байна.

Зөвлөмж

Илрүүлэлт: Тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 171 мэдээллийг оруулахаас 107 мэдээллийг бүрэн оруулж, 64 мэдээллийг хугацаа хоцорч мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д "Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч", Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д "Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч" 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын "Нийцсэн бөгөөд зохистой байх", "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх ёстой бүх мэдээллийг хугацаанд нь бүрэн оруулах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх.

3.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар тус байгууллагын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитын урьдчилсан шатны ажлыг fas.audit.mn системд хийж гүйцэтгэсэн.

3.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар зөрчлийг арилгах, таслан зогсоох 2 төлбөрийн акт хүргүүлж биелэлтийг бүрэн хангуулан [fas](http://fas.audit.mn) системээр үнэлсэн байна. Үүнд:

- Тайлант жилд 985.3 мянган төгрөгийг зориулалт бус зардлын зөрчил илэрч төлбөрийн акт өгсөн
- *Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлсэн байна.*

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	2	985.3	2	985.3	100.0
Нийт дүн	2	985.3	2	985.3	100.0

3.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

4. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа¹ илрээгүй тул залруулга хийгээгүй.

Аудитаар залруулаагүй 2 зөрчил илэрч 2 зөвлөмж хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй 2 зөрчилтэй асуудал нь материаллаг бус зөрчил тул **Өөрчлөлтгүй дүгнэлт** өглөө.

4.1 Зөвлөмж

4.1.1 Санхүүгийн программыг өдөр тутмын ажил гүйлгээндээ ашиглахгүй, бараа материалыг сараар түүвэрлэн сарын сүүлчийн өдөр нэгтгэн нэг удаа программд шивж оруулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т “Тасралтгүй байх зарчим”, 13.1 “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээ үнэн зөв гаргах үндэслэл болно” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаг тухай бүрд нь орлого, зарлагын гүйлгээг программд оруулан шивж байх, санхүүгийн программыг бүрэн эзэмшиж Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах зөвлөмж өгөх

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 6 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Булган аймгийн Булган сумын Спортын төрөлжсөн сургалттай Ерөнхий боловсролын сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Санхүүгийн программыг өдөр тутмын ажил гүйлгээндээ ашиглахгүй байгаа бараа материалыг сараар түүвэрлэн сарын сүүлчийн өдөр нэгтгэн нэг удаа программд шивж оруулсан	1	0					1	0				
Дүн	1	0	-	-			1	0	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 171 мэдээллийг оруулахаас 104	1	0					1	0

Булган аймгийн Булган сумын Спортын төрөлжсөн сургалттай Ерөнхий боловсролын сургуулий
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

мэдээллийг бүрэн оруулж, 3 мэдээлэл хоцорч мэдээлсэн 64 огт мэдээлээгүй байна.								
Дүн	1	0					1	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Тайлант жилийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулаагүй, тендер зарлаагүй	1	0			1	0		
Дүн	1	0			1	0		
Нийт дүн	2	0			1	0	1	0